



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ТӨРИЙН АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГА

Байгууллагын үйл ажиллагааг үр ашигтай удирдаагүй байна



ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН
НАЙРАМДАЛ ЦОГЦОЛБОРЫН
ЗАХИРГАА, САНХҮҮ, АЖ АХУЙН
ЗАРИМ ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХИЙСЭН ЭРСДЭЛИЙН
АУДИТЫН ТАЙЛАН



Гүйцэтгэлийн аудитын
газар



Засгийн газрын IV, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар-15160,
Монгол Улс



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын захиргаа, санхүү,
аж ахуйн зарим үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн аудитын тайлан

**Байгууллагын үйл ажиллагааг
үр ашигтай удирдаагүй байна**

Улаанбаатар

2017 он



Аудитыг гүйцэтгэсэн:

Гүйцэтгэлийн аудитын
газрын захирал бөгөөд
тэргүүлэх аудитор:

М.Давааням

Нийслэлийн аудитын газрын
дэд дарга бөгөөд тэргүүлэх
аудитор:

Б.Мөнх-Очир

Ахлах аудитор:

Л.Хонгорзул

Аудитор:

Б.Анхбаатар

Аудитын тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар
261675, 262451, 263755
дугаарын утас, 323266
дугаарын факсаар
харилцана уу.

**Уг тайланг YAG-ын Веб
сайтаас үзнэ үү.**
www.audit.mn

ХАЯГ:

Үндэсний аудитын газар
Засгийн газрын IV байр,
Бага тойруу-3,
Улаанбаатар-15160
Монгол Улс
www.audit.mn

АГУУЛГА

Аудит хийх үндэслэл, аудитын зорилт.....	3
Аудитын хамрах хүрээ, арга зүй.....	3-4
Аудитад ашигласан шалгуур	4
Товчилсон үгийн тайлбар	5
Ерөнхий мэдээлэл	6

БҮЛЭГ 1. МӨНГӨН ХӨРӨНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГАД НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛЭЭР ТАВИХ ДОТООД ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАНГАЛТГҮЙ БАЙНА

- Санхүү, аж ахуйн үйл ажиллагааг зохицуулах дүрэм, журам,
зохицуулалт хангалтгүй байна7-8
- Өмч хөрөнгөд бүртгэлээр тавих хяналт сул, дотоод хяналт үр
нөлөөгүй хэрэгжиж иржээ 8
- Бусдаас авах 147.8 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд
тусгаагүй, төлбөр тооцоог бүрэн барагдуулаагүй нь орлого дутуу
төвлөрөх нөхцөлийг бүрдүүлжээ 9

БҮЛЭГ 2. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛИЙН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛААГҮЙ БАЙНА

- Хүнсний гол нэр төрлийн материалуудын худалдан авах ажиллагааг
үр ашиггүй зохион байгуулж иржээ..... 10
- Нүүрсний худалдан авалтад хувийн ашиг сонирхол нөлөөлсөн байх
магадлалтай байна11

БҮЛЭГ 3. ТӨРИЙН ӨМЧ, ХӨРӨНГИЙН АШИГЛАЛТ, ТҮҮНД ТАВИХ ХЯНАЛТЫГ ҮР ДҮНТЭЙ ЗОХИОН БАЙГУУЛААГҮЙ БАЙНА

- Байгууллагын эзэмшлийн нутаг дэвсгэрт нэгдсэн төлөвлөлтгүйгээр
барилга, байгууламж олноор баригдаж байгаа нь хүүхдийн
зуслангийн үйл ажиллагаатай нийцэхгүй, дэд бүтэц, инженерийн
байгууламжийн ашиглалт, хүчин чадал, ачаалалд сөргөөр нөлөөлөх
эрсдэлтэй байна 12-13
- Төрийн өмчийг ашиглалтаас хасуулсан үндэслэл нь эргэлзээтэй
байна 13
- Төрийн өмчийг түрээслүүлэхдээ холбогдох журмыг баримтлаагүй,
төлбөрийг бүрэн барагдуулаагүй байна13-14
- Байгууллагын эзэмшлийн нутаг дэвсгэрт иргэн, байгууллагад газар
эзэмших, ашиглах зөвшөөрөл давхардуулан олгож ирсэн нь
холбогдох хуулийг зөрчсөн байна..... 14

БҮЛЭГ 4. АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ҮР АШИГТАЙ ЗОХИОН БАЙГУУЛААГҮЙ БАЙНА

- Төрийн өмч, хөрөнгийг үр ашигтай удирдаагүй, орлого олох болон
зардал бууруулах боломжийг эрэлхийлээгүй байна 15

ДҮГНЭЛТ	16
ЗӨВЛӨМЖ	17-18
ОУХНЦ-оос ирүүлсэн санал	19
Монгол Улсын Ерөнхий Аудиторын тушаал	20



Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2016 оны санхүүгийн тайланд “Мишээл-Од аудит” ХХК аудит хийсэн. Тус аудитаар байгууллагын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд зарим зөрчлүүд илэрч “хязгаарлалттай” дүгнэлт гарсан тул тухайн асуудлуудаар Эрсдэлийн аудит хийх шаардлага үүссэн болно.

Тиймээс Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын зарим үйл ажиллагаанд Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан эрсдэлийн аудитын төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Эрсдэлийн аудитаар Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын захиргаа, санхүү, аж ахуйн зарим үйл ажиллагаанд аудит хийж, дүгнэлт гарган, санал, зөвлөмж боловсруулж Монгол Улсын Ерөнхий аудиторт танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн удирдлага, хяналт үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх;
- Худалдан авалтын үйл ажиллагаа хууль тогтоомжийн хүрээнд хийгдэж байгаа эсэх;
- Өмч, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх
- Аж ахуйн үйл ажиллагааг үр ашигтай удирдан, зохион байгуулж байгаа эсэх.

Аудитын хамрах хүрээ

Аудитад Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2016 оны захиргаа, санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, худалдан авалт, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдлыг хамруулан авч үзнэ.

Хамрах хүрээний асуудлыг нягтлан шалгах, тулган баталгаажуулах, нэмэлт баримт, нотолгоогоор хангах үүднээс холбогдох бусад байгууллагуудаас баримт, мэдээлэл гаргуулж авсан.

Аудитын арга зүй

Аудитыг Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 300, 3000-3100)-ийг ашиглан, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга авах, баримт материалыг



Аудитад ашигласан шалгуур

түүвэрчлэн шалгах, онилсон бүлэгтэй ярилцлага хийх, ажиглалт, ажил гүйлгээний сорил хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан цуглуулсан нотлох баримтад судалгаа, харьцуулалт, дүн шинжилгээ хийж нэгтгэн аудитын дүнг боловсруулж, түүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж өглөө.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- ТБОНӨХБАҮХАТХ
- НББТХ
- Газрын тухай хууль
- ТБОНӨТХ
- Бусад хууль, тогтоомж



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗГ	Засгийн Газар
МУ	Монгол улс
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББТХ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
НОБГ	Нийслэлийн онцгой байдлын газар
ОУХНЦ	Олон улсын хүүхдийн “Найрамдал” цогцолбор
ОУХНТ	Олон улсын хүүхдийн “Найрамдал” төв
ОХУ	Оросын холбооны улс
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХ	Төрийн өмчийн хороо
УСУГ	Ус сувгийн удирдах газар
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ХАХНХЯ	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам
ХЗДХС	Хууль зүй, Дотоод хэргийн сайд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХТҮГ	Хүүхдийн төлөө үндэсний газар
ЭСЯ	Элчин сайдын яам
тн	тонн



Ерөнхий мэдээлэл

Олон улсын хүүхдийн “Найрамдал” цогцолбор (ОУХНЦ) нь 1978 онд байгуулагдсанаас хойш 40 жилийн турш жилийн дөрвөн улирал үйл ажиллагаагаа тогтмол явуулж иржээ.

Тус цогцолбор нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын удирдлагад “Улсын төсөвт үйлдвэрийн газар” статустайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “агентлагын дарга тус агентлагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын захирал төсвийн захирагчийн үүрэг гүйцэтгэдэг.

ОУХНЦ нь СХД-ийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт орших Баянголын хөндийн байгалийн цогцолборт газарт 5300 га газар эзэмшиж байсан байна. Нийслэлийн Засаг даргын 2008 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 298 дугаар захирамжаар 1225 га болгон өөрчилжээ.

ОУХНЦ нь зуны нэг ээлжиндээ 600 гаруй хүүхэд, өвлийн нэг ээлжиндээ 300 орчим хүүхэд хүлээн авах хүчин чадалтай, хүүхдэд зориулсан олон төрлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

ОУХНЦ нь улсын төсвөөс жил бүр 700 гаруй сая төгрөгийн урсгал зардлын санхүүжилт авдаг байсан боловч МУ-ын Засгийн Газрын 2015 оны 501 дүгээр тогтоолын дагуу ажил, үйлчилгээний орлого, байгууллага, иргэдийн хандив, тусламж, бусад эх үүсвэрээс үйл ажиллагааны орлогыг бүрдүүлэхээр болж, улсын төсвөөс олгох санхүүжилт зогсжээ.

2016 оны тайлант жилд тус байгууллага үндсэн үйл ажиллагааны орлогыг 2,557.3 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2,888.6 сая төгрөг буюу 113 хувийн биелэлттэй, туслах үйл ажиллагааны орлогыг 158.8 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 211.4 сая төгрөг буюу 133 хувийн биелэлттэй гарч, нийтдээ 3,100.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлсний 3,097.1 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулжээ.



БҮЛЭГ 1

Мөнгөн хөрөнгийн орлого, зарлагад нягтлан бодох бүртгэлээр тавих дотоод хяналтын үйл ажиллагаа хангалтгүй байна

Санхүү, аж ахуйн үйл ажиллагааг зохицуулах дүрэм, журам, зохицуулалт хангалтгүй байна

1.1 Дулааны цехэд нүүрс хүлээж авах, зарцуулах, хяналт тавих үйл ажиллагааг журамлан зохицуулаагүй, нүүрсний орлого, зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй байгаа нь нүүрсний орлого, зарцуулалт бодитой бус илэрхийлэгдэх нөхцөл үүссэн байна.

- Дулааны цехэд нийлүүлэгдэж буй нүүрсийг хүлээж авах нярав байгаа боловч байнга хүлээж авах боломж байдаггүйгээс ихэнх тохиолдолд станцын инженер хүлээж авч байна. Үүнийг зохицуулсан эрх зүйн актгүй;
- Нийлүүлэгдэж байгаа нүүрсийг машинтай нь жигнэх цахилгаан жин, орлогын талон хэвлэх төхөөрөмж байгаа боловч “талон хэвлэх цаас байхгүй” гэсэн шалтгаанаар жигнэсэн нүүрсийг гар аргаар бүртгэдэг;
- Хүлээн авсан болон зарцуулсан нүүрсэнд агуулахын бүртгэл хөтөлдөггүй,
- Нүүрсний орлого, зарлага, үлдэгдлийн тооцоог дулааны цехийн тооцоотой тулган шалгахад 2014 онд эхний үлдэгдэл 71.0 тн, орлого 1269.0 тн, зарлага 302.0 тн-оор, 2015 онд эхний үлдэгдэл 893.0 тн, орлого 69.6 тн, зарлага 994.2 тн-оор, 2016 онд эхний үлдэгдэл 554.8 тн, орлого 369,8 тн, зарлага 279,3 тн, эцсийн үлдэгдэл 89.9 тн-оор тус тус хоорондоо зөрүүтэй байна.

1.2 Зочид буудлын орлогыг хүлээн авах, бүртгэл тайланд тусгах, хяналт тавих үйл ажиллагааг журамлан зохицуулаагүйгээс Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1¹, 20 дугаар зүйлийн 20.1.1², 20.2.3³, 20.2.4⁴, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Мөнгөн кассын ажиллагааны журам”-ын хэрэгжилт хангалтгүй байна. Энэ нь үйл ажиллагааны орлого үнэн зөв бүртгэгдэхгүй байх, орлого дутуу төвлөрөх эрсдэлийг дагуулж байна.

- Тус цогцолборын харьяа “Марал” зочид буудлын өдөр тутмын ор хоног, хоолны борлуулалтад тавих бүртгэл хяналт, үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан журам, зохицуулалт байхгүй, нягтлан бодох бүртгэл хөтлөлт хангалтгүй, орлогын тайланг 2016 оны 1-9 дүгээр сард гаргаагүй, 10 дугаар сараас шинээр томилогдсон зохион байгуулагч тайлан гаргаж байгаа боловч хариуцсан нягтлан бодогч тайланг хянаж баталгаажуулаагүй;

¹ Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно.

² Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах

³ .холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;

⁴ нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;



- Зочид буудлын орлогыг касс тухай бүрт нь тушаадаггүй, бэлэн мөнгөний орлогын зарим баримтын бүрдэл хангалтгүй, 8 ш нийт 1.7 сая төгрөгийн орлогын баримтад мөнгө тушаагчийн гарын үсэг зурагдаагүй, мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөж ажиллаагүй байна.

Өмч хөрөнгөд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт сул, дотоод хяналт үр нөлөөгүй хэрэгжиж иржээ

1.3 Байгууллагын өмч хөрөнгө, бараа материалын орлого, зардлын гүйлгээнд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна.

- Бараа, материалын үлдэгдэлд түүвэрчлэн хяналтын тооллого хийхэд данс бүртгэлд байгаа дүнгээс зөрүүтэй, агуулахын бүртгэлийг нэр төрлөөр нь бүртгэдэггүй, зарлага гаргахдаа анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй, нярав нь материалын хөдөлгөөний тайлан гаргадаггүй, нягтлан бодогч бараа, материалын тооцоог хянаж, баталгаажуулаагүй;
- 2014 онд 60.0 сая төгрөгийн нүүрс, 9.6 сая төгрөгийн хүнс болон бусад хангамжийн материал, 2015 онд 5.9 сая төгрөгийн хүнс, 4.4 сая төгрөгийн бусад хангамжийн материалыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн байна.

1.4 “Ар Баянгол” ХХК-иас нийлүүлсэн нүүрсний орлого, төлбөр тооцоог давтан шалгахад санхүүгийн ноцтой гэж байж болзошгүй зөрчил илэрсэн тул холбогдох асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлж шалгуулах нь зүйтэй гэж үзлээ.

- Нягтлан бодох бүртгэлээр 2016 оны 4 дүгээр сарын сарын 1-нд 167.0 тн, 4 дүгээр сарын сарын 25-нд 163.0 тн, 6 дугаар сарын сарын 2-нд 43.0 тн нүүрсийг тус тус “Ар Баянгол” ХХК-иас худалдан авснаар бүртгэсэн гүйлгээг тус цогцолборын Дулааны цехэд нүүрс буулгасан жагсаалт, нийлүүлэгчийн санхүүгийн баримттай тулган шалгахад нотлогдоогүй. Нийлүүлэгч “Ар Баянгол” ХХК-д тулган баталгаажуулалт хийх явцад 2016 оны 6 дугаар сарын 2-нд 6.1 сая төгрөгийг ОУХНЦ /Мөнх-Эрдэнэ/-т, 6 дугаар сарын 8-нд 1.0 сая төгрөгийг /Цагаанбаатарт/ тус тус бэлнээр гаргаж өгсөн нь нүүрс нийлүүлэгч компаний тайлбар болон мөнгө хүлээлгэж өгсөн баримтаар нотлогдож байна. Бэлнээр 1.0 сая төгрөгийг авсан Цагаанбаатар нь Найрамдал цогцолборттой шууд гэрээ байгуулж, мах нийлүлдэг “Эй Эн Эм Ди” ХХК-ийн менежер байна.
- “Ар Баянгол” ХХК-иас 2016 оны 3 дугаар сарын 25-нд 1.0 сая төгрөг, 3 дугаар сарын 31-нд 10.0 сая, нийт 11.0 сая төгрөгийг Найрамдал цогцолборын тухайн үеийн дэд захиралд шилжүүлсэн байна.
- Найрамдал цогцолборт тухайн үед ажиллаж байсан нярав нь тус цогцолборын дулааны цехийн инженерээр 2016 оны 6 дугаар сард “2016 оны 3 дугаар сарын нүүрсний зарлагын шаардах хуудсыг алга болгосон тул нөхөж бичиж өгөөч” гэж хүсэн 402.0 тн (16.9 сая төгрөгийн үнэ бүхий) нүүрсний шаардах хуудас бичүүлж, давхардуулан зарлагадсан зөрчлүүд байна.



Бусдаас авах 147.8 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй, төлбөр тооцоог бүрэн барагдуулаагүй нь орлого дутуу төвлөрөх нөхцлийг бүрдүүлжээ

1.5 Тус цогцолбор нь зарим байгууллагад үйлчилгээ үзүүлсний төлбөр болон дутуу төлөгдсөн түрээсийн төлбөрийг данс бүртгэлд тусгаж тайлагнахгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1⁵, 12 дугаар зүйлийн 12.1⁶, 13 дугаар зүйлийн 13.4⁷ дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

- "Молор констракшн" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу ОУХНЦ нь 2014 оны 11 дүгээр сараас 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааны дулаанаар хангасны нийт 140.3 сая төгрөгийн төлбөрөөс 4.0 сая төгрөгийг барагдуулж, үлдсэн 136.3 сая төгрөгийг данс бүртгэлд тусгаж, тайлагнаагүй байна.
- Тус цогцолборын 2016 оны санхүүгийн тайланд "Мишээл Од аудит" ХХК аудит хийж, 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх 124.8 сая төгрөгийн халаалтын авлагыг барагдуулах албан шаардлага хүргүүлсэн байна.
- 2017 оны 4 дүгээр сарын 05-ны байдлаар 143 айлын орон сууцнаас ОУХНЦ-ын баталсан тарифаар тооцож үзэхэд 9.0 сая төгрөгийн цэвэр бохир усны хэрэглээний төлбөр авах тооцоо гарч байна. **Жич:** Ус халаасны төлбөрийг тоолуургүй тул тооцох боломжгүй байна.
- Тус цогцолборын өвлийн байран дахь буфетийн 2016 оны түрээсийн төлбөрийн үлдэгдэл 2.5 сая төгрөгийг бүрэн барагдуулаагүй, дутуу төлбөрийг авлагаар бүртгээгүй байна.

⁵ Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө.

⁶ Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.

⁷ Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.



БҮЛЭГ 2

Худалдан авах үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна

Хүнсний гол нэр төрлийн материалуудын худалдан авах ажиллагааг үр ашиггүй зохион байгуулж иржээ

2.1 ОУХНЦ-т тахианы мах нийлүүлэх гэрээнд оролцогчоос зөвхөн нийлүүлэгч талын санаачилгаар бүтээгдэхүүний үнэнд өөрчлөлт оруулж тендерт оролцогчдод өгөх зааврын 15.10⁸, гэрээний тусгай нөхцөлийн 15.1⁹-ийг зөрчиж тендерт ирүүлсэн үнээс өндөр үнээр бараа нийлүүлжээ.

- 2016-2017 онуудад хүнсний ногоо нийлүүлэх /Багц 06-1/ тендер шалгаруулалтад батлагдсан төсөвт өртөг 37.4 сая төгрөг боловч 7.9 сая төгрөгөөр буюу 21 хувиар хэтэрсэн үний санал ирүүлсэн "Эрдэнэ Энх" ХХК-ийг шаардлага хангасан тендер гэж үзэн 45.2 сая төгрөгөөр гэрээ байгуулж, байгууллагыг төлөөлсөн гарын үсэг зурагдаагүй байхад гэрээг баталгаажуулжээ.
- 2016 онд "Азиалинкс" ХХК-иас 1 кг тахианы гуяыг 6800 төгрөгөөр худалдан авахаар тендерт шалгаруулж, гэрээ байгуулсан боловч гэрээний хэрэгжилтийн явцад нийлүүлэгч нь валютын ханш өссөн шалтгаанаар үнийг 1 кг тутамд 1300 төгрөгөөр нэмэгдүүлж, 2016 оны 10 дугаар сараас 2017 оны 4 дүгээр сар хүртэл нийт 2.3 тн махыг 3.0 сая төгрөгийн нэмэгдэлтэй үнээр худалдан авсан байна.

2.2 Малын махыг худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн 6.1¹¹, 8.2¹²-ийг зөрчиж, тухайн үеийн зах зээлийн үнээс өндөр үнээр худалдан авахаар шууд гэрээ байгуулсан нь худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг алдагдуулсан байна.

- 2016 оны 6 дугаар сарын 27-ноос 9 дүгээр сарын 30-ны хооронд тухайн үед хямд үнээр нийлүүлж байсан "Мах маркет" ХХК-ийн гэрээг үндэслэлгүй цуцалж, "Эй Эн Эм Ду" ХХК-тай шууд гэрээ байгуулан 16.0 тонн мах худалдан авахдаа хонины махыг үхрийн махтай ижил үнээр буюу 1 кг-ийг 7500 төгрөгөөр үнэлж, нийтдээ 120.1 сая төгрөг төлж, нийт 22.3 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулжээ.

2.3 Тус цогцолбор нь бараа материалын жилийн хэрэгцээ, зах зээлийн үнийн судалгаанд суурилсан худалдан авах ажиллагааны төсвийг жил бүр зохиодоггүй өмнөх оны төсвөөр худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгаа нь төсөв хэмнэх, худалдан авах ажиллагаа бодитой бус байх эрсдэлийг үүсгэсэн байна.

⁸ ... тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байна.

⁹ Гэрээний үнэнд тохируулга хийхгүй тогтмол байна.

¹⁰ Шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн тохиолдолд бүх тендерээс татгалзана.

¹¹ Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

¹² Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.



Нүүрсний худалдан авалтад хувийн ашиг сонирхол нөлөөлсөн байх магадлалтай байна

2.4 Өмнө нийлүүлэгдэж байсан нүүрс чанар муутай гэж үзэн “Ар Баянгол” ХХК-тай нүүрс худалдан авах шууд гэрээ байгуулсан нь бусад байгууллагууд тендерт өрсөлдөх боломжийг хязгаарлаж, худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг алдагдуулж ТБОНӨХБАҮХАТХ-ийн 6.1, 8.2-ийг зөрчсөн байна.

- 2016 оны 3 дугаар сарын 16-наас 4 дүгээр сарын 1 хүртэлх хугацаанд тендергүйгээр “Ар Баянгол” ХХК-тай шууд гэрээ байгуулан 1 тонн нүүрсийг 41.8 мянган төгрөгөөр тооцож 707.1 тн нүүрсийг 29.6 сая төгрөгөөр худалдан авч 2.6 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан байна.

2.5 Нүүрс нийлүүлэх тендерийг шалгаруулаагүй байхад 1 тонн нүүрсний худалдан авах үнийг урьдчилан мэдэж байсан. Үнэлгээний хорооны дарга чиглүүлж, зааварчлан тендерийг шалгаруулахдаа хамгийн өндөр харьцуулах үнийн саналыг сонгосон нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 30.1.2¹³, Өрсөлдөөний тухай хууль 11.1.4¹⁴-ийг тус тус зөрчсөн байх магадлалтай байх тул энэ асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлж шалгуулах нь зүйтэй гэж үзлээ.

- Тендер зарлагдахаас өмнө 2016 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ҮХ-ны №2 хурлын тэмдэглэлд үнэлгээний хорооны дарга “Өмнө нь 38.0 мянган төгрөгөөр муу нүүрс ирж байсан, иймээс захиралтай ярьж 1 тонныг нь 50.0 мянган төгрөгөөр нийт 6,200.0 тн нүүрсийг авахаар болсон” гэх утгатай зүйл ярьсан талаар тэмдэглэгдсэн байна.
- 310.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Нүүрс нийлүүлэх тендерт 5 байгууллага материал ирүүлснээс хамгийн өндөр үнэ санал болгосон 2 компаний нэг болох “Ар Баянгол” ХХК-ийг (Налайхын 1 тн нүүрсийг 50.0 мянган төгрөгөөр нийт 6,200.0 тн нүүрс авахаар) тендерт шалгаруулсан.
- Өмнөх онуудад Багануурын 1 тонн нүүрсийг “Багануур илч” ХХК 47.0 мянган төгрөг, “Мон-Хурд” ХХК 47.3 мянган төгрөг, 38.3 мянган төгрөгөөр тус тус нийлүүлж байсан боловч Багануурын нүүрс дулааны зууханд тохирохгүй, чанар муу, ширхэглээгүй, тортог ихтэй гэж холбогдох инженер, ажилчид тайлбар өгсөн.

¹³ Тендер шалгаруулалтад үнийг урьдчилан тохиролцож оролцсон, өрсөлдөгчөө тендер шалгаруулалтын бодит нөхцөлөөс төөрөгдүүлсэн, тэдэнд дарамт, шахалт үзүүлсэн нь шүүх, эрх бүхий байгууллагаас тогтоогдсон бол бүх тендерээс татгалзана

¹⁴ Уралдаант шалгаруулалт, дуудлага худалдаа болон төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцохдоо бараа бүтээгдэхүүний үнэ болон бусад нөхцөл, шалгуурыг урьдчилан тохиролцох



БҮЛЭГ 3

Төрийн өмч, хөрөнгийн ашиглалт, түүнд тавих хяналтыг үр дүнтэй зохион байгуулаагүй байна

Байгууллагын эзэмшлийн нутаг дэвсгэрт нэгдсэн төлөвлөлтгүйгээр барилга, байгууламж олноор баригдаж байгаа нь хүүхдийн зуслангийн үйл ажиллагаатай нийцэхгүй, дэд бүтэц, инженерийн байгууламжийн ашиглалт, хүчин чадал, ачаалалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна:

3.1 Хүүхдийн зуслангийн зориулалтай байгууллагын эзэмшил газар дээр нэгдсэн төлөвлөлтгүйгээр, ашгийн зорилготой хувийн болон нийтийн орон сууц, бусад барилга байгууламж олноор баригдаж байгаа нь хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, хүүхдийн аюулгүй байдал, тав тухыг алдагдуулахаас гадна, эзэмшил газрын хэмжээ буурах, эрчим хүчний хангамж, ачаалал, цэвэрлэх байгууламж, цэвэр усны хангамж, бусад дэд бүтцийн ашиглалтад ихээхэн хүндрэл үүсгэсэн байна.

Тиймээс тэдгээр орон сууц, барилга байгууламж ашиглагчдаас дэд бүтэц, зам талбайн ашиглалт, арчилгаа, цэвэрлэгээний болон цэвэрлэх байгууламж, цэвэр усны ба халуун усны хангамж, үйлчилгээний талаар мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулж, холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэх нь зүйтэй байна.

- 2014 онд ОУХНТ-ийн ерөнхий захирал автограж барихаар төлөвлөгдсөн тус төвийн эзэмшлийн талбайд 2014 оны 2 дугаар сарын 10-ны өдөр “Молор трейд” ХХК-тай 150 айлын орон сууц бариулах, 15 айлын орон сууцыг Найрамдал цогцолборын ажилчдад авах, хуучин зам талбай ногоон байгууламжийг засварлуулах гэрээ байгуулсан байна.
- Одоогийн байдлаар “Молор трейд” ХХК нь 143 айлын 2 блок орон сууцны барилга барьж, 9 айлын орон сууцыг ОУХНЦ-ын ажилчдад банкны зээлээр худалдан борлуулсан, эдгээр айлуудаас 6 айл нь урьдчилгаа төлбөрөө төлж чадахгүй байрандаа ороогүй, 150 хүүхдийн цэцэрлэг баригдаагүй байна. “Молор трейд” ХХК нь орон сууц ашиглалтад орох үед 1 м² талбайг 2.5 сая төгрөгөөр үнэлж, ОУХНЦ-ын ажилчдад 1.5 сая төгрөгөөр тооцож худалдсан бөгөөд одоо энэ байрыг 1 м²-ыг 1.3 сая төгрөгөөр бусад иргэдэд худалдан борлуулж байгаа талаар тус төвийн ажилтнууд мэдээлэл ирүүлсэн.
- Байгуулсан гэрээнд зааснаар захиалагч /ОУХНЦ/ нь инженерийн шугам сүлжээний хүчин чадлын тооцоо хийж, захирамж зөвшөөрөл болон дулаан, усан хангамжийн техникийн нөхцөлүүд холбогдох бичиг баримтыг бүрдүүлж гүйцэтгэгчийн барилга угсралтын ажил гүйцэтгэх эрх зүйн орчинг бүрдүүлэхээр үүрэг хүлээж, “Молор трейд” ХХК нь 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг өөрийн хөрөнгөөр барихаар тус тус тохиролцжээ.

3.2 Албан тушаалтан албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх үедээ хувийн ашиг сонирхол бий болгох болон албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөхүйц



нөхцөл байдал гаргасан байх магадлалтай байна. Тиймээс дээрх асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлж шалгуулах нь зүйтэй байна.

- Тус цогцолбор нь ХАХНХЯ-ны харьяа УТУГ, тус яамны эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд ОУХНЦ-ын эзэмшлийн нутаг дэвсгэрт 143 айлын орон сууц барьсан “Молор констракшн” ХХК-ийг анх тухайн үед тус яамны Сайд үүсгэн байгуулсан, одоогийн эзэмшигч нь түүний ээж, гүйцэтгэх захирал нь хүүхэд нь гэх мэдээлэл байна. Иймээс хүүхдийн зуслангийн эзэмшил нутаг дэвсгэрт тухайн барилгыг бариулахад “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.3¹⁵, 12 дугаар зүйлийн 12.1¹⁶ дэх заалт зөрчигдөж, ашиг сонирхлын зөрчил үүссэн байх магадлалтай гэж үзэж байна.
- 2014 онд ОУХНТ-ийн ерөнхий захирал нь байгууллагын эзэмшил газарт, автограж барихаар төлөвлөгдсөн газрын зориулалтыг өөрчлөх, бусадтай орон сууц бариулах, баригдсан барилгаас зарим орон сууцыг Найрамдал цогцолборын ажилчдад олгуулах гэрээ хийх шийдвэр гаргасан нь хууль эрх зүйн үндэслэлгүй байна.

Төрийн өмчийг ашиглалтаас хасуулсан үндэслэл нь эргэлзээтэй байна

3.3 ТӨХ-ны 2014 оны 385 дугаар тогтоолын дагуу ОУХНЦ-ын 128.9 сая төгрөгийн дансны үнэ бүхий дэлгүүрийн барилгыг актлах шийдвэр гарчээ. Тус тогтоолд “барилгын ашиглаж болох эд зүйлийг ялган тоолж, үнэ тогтоон эргэлтийн хөрөнгөд ашиглах, журмын дагуу худалдан борлуулж, тогтоолын биелэлтийг ТӨХ-нд 2014 оны 3-р улиралд багтаан ирүүлэх”-ийг үүрэг болгожээ.



Үүний дагуу 2015 оны 1 дүгээр сарын 12-нд ОУХНЦ-ын өмч хамгаалах зөвлөл байгууллагын ажилтан, албан хаагчид, оршин суугчдад хэрэгцээтэй дэлгүүр ажиллуулах эрхийг хадгалж, үргэлжлүүлэн ашиглахыг Захиргааны зөвлөл, Санхүү бүртгэлийн хэлтэст санал болгосон байна. Гэвч тус барилгыг сэргээн засварлах төсөв хөрөнгө байхгүйгээс одоог хүртэл ямар нэг арга хэмжээ аваагүй байна. Эдгээр зөрүүтэй нөхцөл байдлаас харахад тус дэлгүүрийн барилгыг акталсан шийдвэрийн үндэслэлийг дахин хянуулах шаардлагатай байна.

Төрийн өмчийг түрээслүүлэхдээ холбогдох журмыг баримтлаагүй, төлбөрийг бүрэн барагдуулаагүй байна

¹⁵ Албан тушаалтан албаны бүрэн эрхээ хувийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн зорилгод ашиглахгүй бөгөөд албан үүрэгт нь нөлөөлөхүйц аливаа харилцаанаас ангид байна.

¹⁶ Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.



3.4 Тус цогцолборын түргэн үйлчилгээний цэг, дэлгүүрийг түрээслүүлэхдээ холбогдох байгууллагаас зөвшөөрөл аваагүй, түрээслэгчийг сонгон шалгаруулалтаар шалгаруулаагүй, түрээсийн төлбөрийг бүрэн аваагүй, нягтлан бодох бүртгэлд авлагаар тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх заалт, Засгийн Газрын 2001 оны 134 дүгээр тогтоолын 6¹⁷, 7¹⁸, 8¹⁹ дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

- Түргэн үйлчилгээний цэг, дэлгүүрийн түрээсийн гэрээний хугацаа дууссан боловч гэрээг сунгаагүй, түрээсийн орлогыг бүрэн барагдуулаагүй, авлагаар бүртгээгүй, төрийн өмчийг түрээслүүлэхдээ ТӨБЗГ-аас зохих зөвшөөрөл аваагүй байна.

3.5 Орон сууц, зуслангийн зориулалтаар газар эзэмшүүлэх гэрчилгээ олгосон нь орон сууц, зуслангийн зориулалттай барилга байшингууд олноор баригдах нөхцөлийг бий болгож байна.

- ОУХНЦ нь 2008 он хүртэл СХД-ийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт орших Баянголын хөндийн байгалийн цогцолборт газарт 5300 га газар эзэмшиж байсан байна. Нийслэлийн Засаг даргын 2008 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 298 дугаар захирамжаар эзэмшил газар 1225 га болгон өөрчлөгдөж хүүхдийн зуслангийн зориулалтаар эзэмшүүлэхээр болсон. Гэвч удалгүй Нийслэлийн Засаг даргын 2009 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 527 дугаар захирамжаар газрын зориулалтыг хүүхдийн зуслан, орон сууц, зуслангийн зориулалтаар эзэмшүүлэхээр шийдвэр гарч гэрчилгээ олгогдсон байна.

Байгууллагын эзэмшлийн нутаг дэвсгэрт иргэн, байгууллагад газар эзэмших, ашиглах зөвшөөрөл давхардуулан олгож ирсэн нь холбогдох хуулийг зөрчсөн байна

3.6 Нийслэлийн Газрын албаны кадастрын мэдээллийн санд ОУХНЦ-ын кадастрын зураг дахь солбилцол бүхий газрын мэдээлэл бүртгэлгүй, Нийслэлийн газрын кадастрын мэдээллийн сангийн систем хуучирч газрын албаны үйл ажиллагаа, газар олголтонд мэргэжлийн хяналт тавих боломжийг хааж, газар эзэмшигч, ашиглагч, өмчлөгчдийг эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг алдагдуулж байна.

- ОУХНЦ-ын эзэмшиж буй 1225 га газар дээр 2005-2016 онуудад Нийслэл болон Дүүргийн Засаг даргын захирамжаар ОУХНЦ, УСУГ, ОХУ-ын ЭСЯ, НОБГ-аас гадна нийт 95 нэгж талбарт газар эзэмших, ашиглах эрхийг өөрчлөх, сунгах, шинээр олгох байдлаар иргэд, байгууллагуудад давхардуулан олгосон байна. Энэ нь Газрын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3²⁰ дэх заалтыг зөрчсөн байна.

¹⁷ Түрээслүүлэгч нь нэг зориулалттай, нэгдмэл байдалтай ашиглагдах цогцолбор төрийн өөрийн өмчийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх эд хөрөнгийг түрээслүүлэхдээ холбогдох яамны саналыг авна.

¹⁸ Түрээслүүлэгч болон түрээслэгчийн хоорондын харилцааг хууль тогтоомж, энэ журамд заасны дагуу байгуулсан түрээсийн гэрээгээр зохицуулна.

¹⁹ Төрийн өөрийн өмчийн тухайн эд хөрөнгийг хоёр буюу түүнээс дээш этгээд түрээслэх бол түрээсийн гэрээний нөхцөлийг түрээслэгч, түрээслүүлэгч харилцан тохиролцоно.

²⁰ Хүсэлт гаргасан газар нь бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай ямар нэг хэмжээгээр давхцаагүй байна.



БҮЛЭГ 4

Аж ахуйн үйл ажиллагааг үр ашигтай зохион байгуулаагүй байна

Төрийн өмч, хөрөнгийг үр ашигтай удирдаагүй, орлого олох болон зардал бууруулах боломжийг эрэлхийлээгүй байна

4.1 Цэвэр бохир болон хэрэглээний халуун усаар үнэ төлбөргүй, эсхүл өртгөө нөхөхгүй үнээр ашиглуулж ирсэн нь үндсэн бус үйл ажиллагааны орлого олох боломжийг алдсан, үйл ажиллагааны зардлыг хэмнэх боломжийг бүрдүүлээгүй байна.

- ОУХНЦ нь Нийслэлийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн дулаан үйлдвэрлэх 12/2015, дулаан түгээх 13/2015, дулаанаар зохицуулалттай хангах 14/2015 тоот тусгай зөвшөөрлийн дагуу өөрийн уурын зуухнаас үйлдвэрлэж буй халуун ус, дулаанаар өөрсдийн байрнуудаас гадна ажилчдын 18 айлын 3 орон сууц, 25 айлын 1 орон сууц, хувьчлагдсан 18 айлын 1 орон сууц, хувийн 20, 24 айлын 2 орон сууц, 6 иргэний амины орон сууц, 4 ААН-ийн ажлын байр, "Молор констракшн" ХХК-ний барьсан 143 айлын 2 блок орон сууцыг ханган ажиллаж байгаа нь дулааны цехийн нийт дулаанаар хангаж буй талбайн 46 орчим хувийг эзэлж байна.
- Энэ нь дулааны цехийн ачаалал, дулаан үйлдвэрлэх өртгийг нэмэгдүүлж, зардлаа нөхөж чадахгүй, нүүрс нийлүүлэгч компанид 2016 оны жилийн эцсийн байдлаар 92.0 сая төгрөгийн өглөгтэй гарахад хүргэсэн байна.
- 2016 онд тус цогцолборын байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 2015 онтой харьцуулахад 13 хувиар буюу 64.1 сая төгрөгөөр өссөн. Тухайлбал: гэрэл, цахилгааны зардал 9.4 сая, цэвэр, бохир усны зардал 22.7 сая, түлш, халаалтын зардал 31.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь шинээр дулаан, цахилгаан, ус хэрэглэгчдийн тоо нэмэгдсэн, тэдгээр хэрэглэгчдэд холбогдох төлбөр, тооцоог бүрэн тооцож авахгүй байгаагаар холбоотой байна.

4.2 ОУХНЦ-ын ерөнхий захирал нь эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр ХАХНХЯ, ХТҮГ болон харилцагч байгууллагуудад Найрамдал зусланд амрах эрхийн бичгийг үнэ төлбөргүй олгох, хөнгөлөлт үзүүлэх, үйлчилгээний төлбөрөөс чөлөөлөх зэргээр үндсэн үйл ажиллагааны орлогыг бууруулж ТБОНӨТХ-ийн 30 дугаар зүйлйн 30.3²¹ дахь заалтыг зөрчсөн байна.

- ОУХНЦ-ын ерөнхий захирлын зөвшөөрлөөр 2016 онд 167 хүүхдийг 34.5 сая төгрөгийн төлбөрөөс 100 хувь чөлөөлж үнэ төлбөргүй амраасан;
- 2015-2016 онд 4 аж ахуйн нэгжид гэрээ хэлцэл, тушаал шийдвэргүйгээр үнэ төлбөргүй буюу хөнгөлөлттэй үнээр 9.3 сая төгрөгийн үйлчилгээг үзүүлсэн;
- Байгууллага, иргэдээс 4.3 сая төгрөгийн үйлчилгээний төлбөрийг аваагүй, данс бүртгэлд авлагаар тусгаж, тайлагнаагүй;

²¹Төрийн өмчийн эд хөрөнгийг ... эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх... ийг хориглоно.



Дүгнэлт:

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын зарим үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- Санхүү, аж ахуйн үйл ажиллагааг зохицуулах дүрэм, журам, дотоод хяналтын тогтолцоо хангалтгүй, өмч хөрөнгөд бүртгэлээр тавих хяналт сул, зарим авлагыг нягтлан бодох бүртгэлд тусгадаггүй, төлбөр тооцоог бүрэн барагдуулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.
- Худалдан авах ажиллагааны төлөвлөлт хангалтгүй, хугацаа алддаг, хууль журмын дагуу зохион байгуулаагүй, хувийн ашиг сонирхол нөлөөлсөн байх үндэслэлтэй байгаа зэрэг нь худалдан авах ажиллагааны гүйцэтгэл, үр дүнд сөргөөр нөлөөлсөн байна .
- Байгууллагын эзэмшлийн нутаг дэвсгэрт нэгдсэн төлөвлөлтгүйгээр барилга, байгууламж олноор баригдаж байгаа нь хүүхдийн зуслангийн үйл ажиллагаатай нийцэхгүй, дэд бүтэц, инженерийн байгууламжийн ашиглалт, хүчин чадал, ачаалалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй бөгөөд газар эзэмших, ашиглах зөвшөөрөл давхардуулан олгож ирсэн нь холбогдох хуулийг зөрчсөн байна.
- Байгууллагын эзэмшлийн нутаг дэвсгэрт харьяалах яамны сайдын үүсгэн байгуулсан, нэгдмэл сонирхол бүхий компани орон сууцны болон бусад барилга барих шууд гэрээ байгуулжээ.
- Төрийн өмчийг ашиглалтаас хасуулсан үндэслэл нь эргэлзээтэй, түрээсийн гэрээ байгуулахдаа холбогдох журмыг баримтлаагүй, төлбөрийг бүрэн барагдуулаагүй, данс бүртгэлд авлагаар тусгаж тайлагнаагүй байна.
- Төрийн өмч, хөрөнгийг үр ашигтай удирдаагүй, орлого олох болон зардал бууруулах талаар идэвхи санаачилгагүй ажиллаж ирсэн байна.
- Аудитаар илэрсэн нүүрсний худалдан авалт, орон сууцны барилга барих гэрээ, дулааны төлбөр тооцоотой холбоотой асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулах шаардлагатай байна.



Зөвлөмж:

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд:

- Олон Улсын хүүхдийн Найрамдал цогцолборын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, аудитаар илэрсэн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч, биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт:

- Олон Улсын хүүхдийн Найрамдал цогцолборын санхүү, аж ахуйн зарим үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулах, цаашид давтан гаргуулахгүй байхад анхаарлаа хандуулж, дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлж ажиллах.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт:

- ТӨХ-ны 2014 оны 385 дугаар тогтоолоор ОУХНЦ-ын 128.9 сая төгрөгийн балансын үнэ бүхий дэлгүүрийн барилгыг акталж данс бүртгэлээс хассан шийдвэрийн үндэслэлийг дахин хянаж, биелэлтийг 2017 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Олон Улсын хүүхдийн Найрамдал цогцолборын захиргаанд:

1. Санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын чиглэлээр:

- Байгууллагын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, бараа материалын хөдөлгөөний тайланг сар бүр нэр төрлөөр нь гаргуулж, үлдэгдлийг баталгаажуулах, зочид буудал, хоолны борлуулалт, дулааны цехийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах, эдгээрт тавих хяналтын талаар журам боловсруулан батлуулж мөрдөх;
- Дулаан, цэвэр бохир ус, халуун усаар хангах үнэ тарифыг Эрчим хүчний зохицуулах хороогоор батлуулах, байгууллага, иргэдийн байрны талбайн хэмжилтийг дахин хийж, баталгаажуулан, батлагдсан тарифын дагуу гэрээг шинэчлэх, дутуу төлөгдсөн өр төлбөрүүдийг нягтлан бодох бүртгэлд авлагаар бүртгэж, барагдуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

2. Худалдан авах ажиллагааны чиглэлээр:

- Худалдан авах ажиллагааны төсвийг бараа материалын хэрэгцээ, шаардлага, зах зээлийн үнийн судалгаанд суурилан үндэслэлтэй боловсруулан баталж, батлагдсан төсвийн хүрээнд ТБОНӨХБАҮХАТ хуулийг мөрдлөг болгон зохион байгуулах, цаашид шууд гэрээ байгуулдаг явдлыг бүрэн зогсоож, худалдан авах ажиллагааны чиглэлээр ажилчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтанд хамруулах.



3. Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын чиглэлээр:

- ОУХНЦ-ын эзэмшил газрын кадастрын зураглал дахь солбицол бүхий газар нь Нийслэлийн Газрын кадастрын мэдээллийн сангийн архивын мэдээлэлд бүртгэгдээгүй асуудлыг судалж, холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх, газар эзэмших, ашиглах эрх давхардуулан олгосон байдлыг хууль, хяналтын байгууллагад хандан шалгуулах замаар үүссэн давхардлыг арилгуулах.

4. Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:

- Байгууллагын удирдлагаас гаргаж байгаа шийдвэр, байгуулсан гэрээ, дотооддоо баталж, мөрдүүлэх журам, зохицуулалтын баримт бичгийн боловсруулалт, чанар, эрх зүйн үндэслэлийг зохих түвшинд хангуулж ажиллах.
- Байгууллагын үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомж, дүрэм журмын хүрээнд удирдан зохион байгуулахад анхаарч, аудитаар илэрсэн алдаа, зөрчилд дүгнэлт хийж, тэдгээрийг арилгах чиглэлээр өгөгдсөн дүгнэлт, зөвлөмжүүдийн хэрэгжилтийг хангуулж, биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.



Олон улсын хүүхдийн найрамдал цогцолбороос аудитын тайланд ирүүлсэн санал



ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН НАЙРАМДАЛ ЦОГЦОЛБОР

18220 Улаанбаатар хот, Сөнмиохайрхан дүүрэг,
Утас: 7049 8001, 7049 8008, Факс: (975-11) 7049 8002,
E-mail: icc@naibamdal.mn, <http://www.naibamdal.mn>

2017 05.06 № 021
тантай _____ -ны № _____ -т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Тус цогцолборт хийгдсэн эрсдэлийн аудитын
тайлангийн төсөлтэй танилцлаа.

Төсөлд тусгайлан өгөх саналгүй болно.
Дүгнэлт зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган,
хэрэгжүүлж ажиллахаа үүгээр уламжилж байна.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ  О. ДОРЖСҮРЭН



D:\file\Албан бичиг\2017\221 а5.docx



Аудитын тайлан баталгаажуулах тухай Ерөнхий аудиторын тушаал



2017 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/90

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2015 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12 дугаар дугаар зүйлийн 12.39 дэх заалт, мөн 2003 оны 53 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Олон Улсын хүүхдийн Найрамдал цогцолборын захиргаа, санхүү, аж ахуйн зарим үйл ажиллагаа"-нд хийсэн эрсдэлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Олон Улсын хүүхдийн Найрамдал цогцолборт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилган, өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Олон Улсын хүүхдийн Найрамдал цогцолборын ерөнхий захирал /О.Доржсүрэн/-д зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор /М.Давааням/-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Tushaas\2017\0515\GAAG\2.docx.docx

070283

